

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2024.12.02 № 03/1973

таний -ны № -т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Хөшигийн хөндий туннел” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Төв, Хөшигийн хөндий/ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга хүссэнтэй холбогдуулан дараах хариуг хүргүүлж байна.

Д/д	Оролцогчийн тодруулга	Тодруулгын хариу
1	<p>Тендерийн баталгааг гаргуулахад ямар шаардлага тавих вэ? Гадаадын томоохон банкнуудын гаргасан тендерийн баталгааг хүлээж авах уу?</p> <p>Тендерийн баталгаанд хүлээн авагчийн нэр, банкны нэр болон хаяг нь тодорхой бус байгааг тодруулах.</p>	Төрийн худалдан авах цахим систем https://www.tender.gov.mn/mn/rules/list - д байршуулсан тендерийн баталгааны журмыг баримтална.
2	Үнийн саналын маягт болон үнийн саналын задаргааны маягт өгч болох үү?	Үнийн саналын маягт болон үнийн саналын задаргааны маягт гэж тусгайлсан маягт байхгүй. Тендерийн сонирхогч этгээд өөрсдөө боловсруулж ирүүлнэ.
3	55,3 тэрбум төгрөгийн төсөвт НӨАТ болон татвар шингэсэн уу? Гадаадын тендерт оролцогчид одоогоор Монгол Улсад төлөх татварын хэмжээ тодорхойгүй байна. Тендерийн үнэд НӨАТ болон татвар шингэсэн үнийн санал өгөх үү?	Монгол Улсын хууль, тогтоомж, ТШЗ-ны 21 дэх хэсэгт заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.13-т заасан зардлууд багтсанд тооцно.
4	Техникийн саналд ямар нэгэн форматын шаардлага байгаа юу? Цахим тендерийн баримт бичгийн хэмжээ багтаамжид хязгаар байгаа юу?	ТШЗ-ны “Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ хэсгийн 25.1” хэсгийг баримтална. Цахим системээр илгээх баримт бичгийн хэмжээ 15 МБ бүхий 10 файл илгээх боломжтой. /15 MB – 10 files/
5	Энэхүү төсөлд урьдчилгаа төлбөр байхгүй гэж ойлголоо, гэрээний нөхцөл дээр тодорхой төлбөрийн төлөлтийн төлөвлөгөө байхгүй байна.	Тендерийн баримт бичгийн II бүлгийн Өгөгдлийн хүснэгтийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 37.1-д “Урьдчилгаа төлбөр олгохгүй” гэж заасан. Тендерийн баримт бичгийн Гэрээний тусгай

	<p>Төлбөрийг авах ямар арга байдаг вэ?</p> <p>Тендерт оролцогч тендерийн саналдаа төлбөрийн үе шат, төлөлтийн төлөвлөгөөг гаргаж өгөх шаардлагатай юу?</p>	нөхцөл хэсгийн ГЕН 5.6-д төлбөр төлөх хугацааг заасан.
6	<p>Төслийг хэрэгжүүлэх хугацаа нь гэрээ байгуулснаас хойш 6 сарын дотор гэсэн байна."6 сарын дотор" гэдэг нь үр дүнг ирүүлэх хугацаа эсвэл бүх баримт бичгийг бүрэн батлах хугацааг хэлж байна уу?</p> <p>Төслийн ТЭЗҮ, урьдчилсан зураг төсөл боловсруулах зэрэгт тодорхой хугацаа заасан уу?</p>	<p>1. Ажлын даалгаврын 8 дугаар бүлэгт баримт бичгийг бүрэн батлах хугацаа гэж ойлгож болно. /Эцсийн тайлан хүлээж авах хугацаа/</p> <p>2. Төслийн ТЭЗҮ болон зураг төслийг тус тус боловсруулах тодорхой хугацаа заагаагүй, сонирхогч этгээд ажил гүйцэтгэх хуваарийг гарган ирүүлнэ.</p>
7	Техникийн саналд ямар нэгэн жишиг маягт форматын шаардлага байгаа юу?	Тендерийн жишиг баримт бичиг, Тендерийн өгөгдлийн хүснэгтийн дагуу тендерийг бэлтгэж ирүүлнэ. /Тендер шалгаруулалтын зааварчилгааны 13 дахь хэсэг/
8	<p>Тендерийн баримт бичгийн IV бүлгийн тендерийн үнэлгээний заавар аргачлал журам, онооны хувийн жинг өгөх боломжтой юу?</p> <p>Үнэлэх болон шийдвэр гаргах аргачлалыг тус тус салгаж тусгасан эсэх?</p>	Тендерийн баримт бичгийн IV бүлэгт тендерийн үнэлгээнд Тендерийн өгөгдлийн хүснэгтэд зааснаас өөрөөр нэмэлт шалгуур үзүүлэлт байхгүй.
9	Төслийн ажилтнуудад олон улсын төслийн туршлага шаардагдах бол Монгол Улсаас гаднах бүх төслүүдийг олон улсын төсөлд тооцож болох уу?	<p>1. Хэрвээ Монгол улсын иргэн бол гадаад улс орнуудад, харин гадаад улсын иргэн бол өөрийн улсаас гадна бусад улс оронд ижил төстэй төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байснаар ойлгоно.</p> <p>2. Монгол улсаас өөр бусад улс орнуудад хэрэгжсэн төслийг олон улсын төсөл гэж ойлгож болно. Гэхдээ сонирхогч этгээдийн өөрийн улс орондоо хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийг тооцохгүй.</p>
10	<p>Ижил төстэй ажлын туршлагын тавигдах шаардлага: Тендерт оролцогч нь ижил төстэй 2 зураг төслийн ажлын гэрээг гүйцэтгэсэн бөгөөд хэрэгжиж буй 1 зураг төслийн гэрээг ирүүлэх гэсэн ойлголт зөв үү?</p> <p>3-аас доошгүй удаа ижил төстэй ажил хийсэн байх гэдэг нь дор хаяж хоёр ажил дуусгасан, нэгийг хэрэгжилтийн шатанд байж болно гэсэн шаардлагатай юу?</p> <p>Дууссан гэдэг нь зураг төслийн ажил дууссан гэсэн үг үү?</p> <p>Газар доорх метроны зураг төслийн</p>	<p>Зөв. Тендерийн баримт бичгийн Өгөгдлийн хүснэгтийн 19.1.3 дахь заалт: Оролцогч этгээд нь сүүлийн 8 жилийн хугацаанд 3 -аас доошгүй удаа ижил төстэй ажил хийсэн байх ба ижил төстэй ажил тус бүр нь төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй байна. Мөн ижил төстэй ажилд тооцуулахаар ирүүлсэн 1 ажил нь хэрэгжилтийн шатандaa байж болно.</p> <p>Тийм.</p> <p>Дээрх заалтын дагуу ажил хийсэн гэдэгт зураг төслийн ажлыг бүрэн дуусгаж, гэрээ дүгнэж, ажил хүлээлцсэн баримт үйлдсэн байхыг ойлгоно.</p> <p>Газар доорх метроны зураг төслийн ажлыг</p>

	ажлыг ижил төстэй ажлын туршлагад хамрагдана гэж авч үзэж болох уу?	ижил төстэй ажилд тооцохгүй.
11	Тендерт шалгарсан гадаадын оролцогч Монгол Улсад зураг төсөл, судалгааны ажлыг гүйцэтгэх, мөн төлбөр хүлээн авахын тулд Монгол Улсад компания бүртгүүлэх шаардлагатай юу? Захиалагч тал нь гадаадын тендерт оролцогчдод гадаад гүйвуулгаар төлбөрийг шуд шилжүүлэх боломжтой эсэх?	Тендер зохион байгуулах Үнэлгээний хорооны ажлын чиг үүрэгт хамаарахгүй.
12	Тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 хоногоор сунгах боломжтой эсэх	Тендерийн хүлээн авах эцсийн хугацааг дахин сунгах боломжгүй, энэхүү төсөл нь 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжих хугацааг баримтална.
13	Тендерт яаж бүртгэх болон оролцох эрх үүсгэх	Цахим системд бүртгүүлэх болон тендер илгээх талаар www.tender.gov.mn сайтаар орж Сургалт>Гарын авлага> Нийлүүлэгчийн удирдлагын систем>Нийлүүлэгчийн гарын авлага цэсээс “supplier handbook.pdf” файлыг татаж авч хэрхэн тендерт оролцох талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.
14	Үйлчилгээний хураамж “50.000” төгрөгийг яаж, ямар дансанд хийх	Тендерийг цахим шуудангаар бус цахим систем (tender.gov.mn)-нд өөрийн хэрэглэгчийн эрхээр нэвтрэн орж зааврын дагуу тус системээр илгээнэ.
15	Тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим шуудангаар хэрхэн хүлээж авах дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.	Тендерийг цахим шуудангаар бус цахим систем (tender.gov.mn)-нд өөрийн хэрэглэгчийн эрхээр нэвтрэн орж зааврын дагуу тус системээр илгээнэ.
16	Дээрх тендерт оролцож баталгаажуулахын тулд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-д өөрийн нэвтэрч тендерт оролцох цэсийг сонгоход “Тендерийн баримт бичгийн төлөв оролцох боломжгүй төлөвтэй байна” гэсэн алдаа зааж цааш үргэлжлүүлэх боломжгүй байгаагаас гадна тодруулга хүсэх боломжгүй байна.	Яг ямар алдаа зааж байгаа талаар Худалдан авах ажиллагааны цахим системийн цахим хаяг: it@procurement.gov.mn -аар хандаж (тухайн алдааны зургийг хавсаргах), Төрийн худалдан авах ажиллагааны газар (Засгийн газрын 9-р байр)-т, мөн лавлах 79790000 дугаарын утсанд хандаж тус тус шийдвэрлүүлэх боломжтой.
17	Тендерийн Ажлын даалгаврыг англи хэл дээр цахим системд байршуулж өгнө үү.	Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 12.1 дэх заалтад заасны дагуу Тендерийн баримт бичиг Монгол хэлээр байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хургуулсэнд тооцно.